



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (395)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Тангараг өргөх ёслолын журам батлах тухай*
- *Цол олгох журам батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
("Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр)

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны дөрөвдүгээр сарын 14

№14 (395)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 658. | Дашбалжирын Баттөр, Хургын Дашдэлэг
нарт Монгол Улсын гавъяат барилгачин
цол хүртээх тухай | Дугаар 47 | 322 |
| 659. | Тангараг өргөх ёслолын журам батлах тухай | Дугаар 50 | 322 |
| 660. | Цол олгох журам батлах тухай | Дугаар 51 | 323 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 661. | Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай | Дугаар 44 | 325 |
|------|--|-----------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|------|--|--------------|-----|
| 662. | Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтуудыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 02/02 | 336 |
|------|--|--------------|-----|



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Дашбалжирын Баттөр, Хургын Дашдэлэг нарт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай

Барилгын үйлдвэрлэлийн салбарт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн хамт олныг чадварлаг удирдан зохион байгуулж үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууцны олон барилгыг чанартай барьж ашиглалтад оруулан барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн барилгын үйлдвэрлэлийн "Жигүүр гранд" ХХК-ийн ерөнхий

захирал Дашбалжирын Баттөр, Дархан-Уул аймгийн барилгын үйлдвэрлэлийн "Баянгийн-Эх" ХХК-ийн захирал Хургын Дашдэлэг нарт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Тангараг өргөх ёслолын журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

"Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн

тангараг өргөх ёслолын журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ

*Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны
04 дүгээр сарын 04-ний өдрийн 50 дугаар
зарлигийн хавсралт*

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын иргэн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд томилогдохдоо Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тангараг(цаашид "тангараг" гэх)-ийг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Тангараг өргөх нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн нэр төрийн хэрэг бөгөөд түүнд төрөөс итгэл, хариуцлага хүлээлгэж, хүндэтгэл үзүүлж байгаагийн илэрхийлэл болно.

Хоёр. Тангараг өргөх ёслолын ажиллагааны
зохион байгуулалт

2.1. Тангараг өргөх газар, хугацаа/өдөр, цаг/-г Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эсхүл аймаг, нийслэлийн хэлтэс, газрын дарга, тусгай ангийн дарга тогтоох

бөгөөд тангараг өргөх ёслолын ажиллагааг тангараг өргөх албан хаагч(цаашид "тангараг өргөгч" гэх) -ийн ажилладаг байгууллага зохион байгуулна.

2.2. Тухайн байгууллагын төрийн захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан эсхүл байгууллагын эрх баригчийн томилсон албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг энэ журамд заасны дагуу хангаж, удирдана.

2.3. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд тангараг өргөгч, түүнийг шууд захирах албан тушаалтан оролцох бөгөөд байгууллагын бусад албан хаагчдыг зохион байгуулалттайгаар оролцуулна.

2.4. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд төрийн захиргааны болон нутгийн захиргааны бусад байгууллага, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж болно.



2.5. Тангараг өргөх ёслолын ажиллагаа болох газар (байр) ыг ёслол, хүүхдэдтэйгийн байдалтайгаар тусгайлан бэлтгэнэ.

2.6. Тангараг өргөх ёслолын ажиллагаа болох газар (байр)-т Монгол Улсын Төрийн сүлд, далбаа хүндэтгэлтэйгээр байрлуулна.

2.7. Тангараг өргөх ёслолын ажиллагаа болох газарт онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бэлгэдэл, туг, аврах ажлын зориулалттай техник хэрэгслийг тусгайлан бэлтгэж байрлуулж болно.

2.8. Тангараг өргөгч тангараг өргөх ёслолын ажиллагаа болох газар(байр)-т тогтоосон цагт ёслолын хувцастай ирж Монгол Улсын Төрийн сүлд рүү эгц харан зогсоно.

2.9. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөгчийг танилцуулж, тангарагийн бичгийг тус бүрт нь гардуулна.

2.10. Тангарагийн үг бүхий бичгийг гардуулахад тангараг өргөгч тангарагийн үгийг цээжээр хүндэтгэлтэйгээр дуудна.

2.11. Хэд хэдэн тангараг өргөгч байгаа бол нэсаар хамгийн эхмэд нь тангарагийн үгийг дуудаж бусад нь дагалдана.

2.12. Байгууллага, хамт олноороо тангараг өргөх бол тухайн байгууллага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга тангарагийн үгийг дуудаж бусад нь дагалдана.

2.13. Тангарагийн үгийг дуудаж дууссаны дараа тангараг өргөгч Монгол Улсын Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө зүүн өвдөг дээрээ сөхрөн адис авна.

2.14. Тангараг өргөгч нүүрэн талдаа Монгол Улсын Төрийн сүлд, "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын албан хаагчийн тангараг" гэсэн бичээстэй, дотор талдаа Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29.3-т заасан тангарагийн бичигт гарын үсэг зурж, он, сар, өдрийг бичнэ.

2.15. Тангараг өргөж дуусмагц хөгжимд Монгол Улсын төрийн дуулал эгшиглэнэ.

2.16. Тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөгчид баяр хүргээд ёслолын ажиллагааг хаана.

2.17. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаарх дэс дарааллыг тодорхой тусгасан тэмдэглэл хөтөлнө.

Гурав. Бусад зүйл

3.1. Тангараг өргөх ёслолын ажиллагааг эх орны түүхэн дурсгалт газар, хөшөө, цогцолборын дэргэд, баярын болон тэмдэглэлт өдөр, ой, түүхэн үйл явдлыг тохиолдуулан зохион байгуулж болно.

3.2. Тангараг өргөх ёслолын ажиллагааг тохиолдуулан ёслол хүндэтгэл (урлаг, спортын болон бусад)-ийн арга хэмжээг зохион байгуулж болно.

3.3. Тангарагийн бичгийн загварыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

3.4. Тангарагийн бичгийг тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хавсаргаж хадгална.

3.5. Тангараг өргөсөн албан хаагч төрийн бусад байгууллагад шилжин ажилласны дараа онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаалд эргэн томилогдвол дахин тангараг өргөхгүй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Цол олгох журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан хаагчийн цол олгох журам"-ыг амьсралтын ёсоор баталсугай.

2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн албан тушаалын ангилал, цолны

зэрэглэлийг энэхүү журамтай нийцүүлэн тогтоохыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд /У.Хүрэлсүх/-д даалгасугай.

3. Энэхүү журмыг зарлиг гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны
04 дүгээр сарын 04-ний өдрийн 51 дугаар
зарлигийн хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИЙН ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчид хуульд заасан цол олгохдоо энэхүү журмыг баримтлана.

1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн цол нь түүний албан тушаалын ангиллын илэрхийлэл мөн бөгөөд тусгай албан тушаалын ангилал бүр цолны нэг зэрэглэлтэй байна.

1.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалтны жэгсаалт, албан хаагчийн албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаал эрхэлдэг албан хаагчийн цол, зэрэглэл нь түүнд хууль, дүрмээр тогтоосон эрх, үүргээ хэрэгжүүлэх баталгаа, мөнгөн болон материалын хангалтын хэмжээг тодорхойлох үндэслэл болно.

Хоёр. Цол олгох

2.1. Дор дурдсан албан тушаалтан онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаал эрхэлж байгаа албан хаагчид цол олгох эрхтэй:

2.1.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;

2.1.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга;

2.1.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн тусгай ангийн дарга;

2.1.4. Аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн хэлтэс, газрын дарга.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан эрх бүхий албан тушаалтан дараах цол олгоно.

2.2.1. Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн:

2.2.1.1. Тэргүүн комиссар;

2.2.1.2. Комиссар.

2.2.2. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга:

2.2.2.1. Дээд ахмад;

2.2.2.2. Тэргүүн ахмад;

2.2.2.3. Шадар ахмад;

2.2.2.4. Дээд дэслэгч;

2.2.2.5. Тэргүүн дэслэгч;

2.2.2.6. Шадар дэслэгч;

2.2.2.7. Шадар түрүүч.

2.2.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн тусгай анги, аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн хэлтэс, газрын дарга:

2.2.3.1. Дээд түрүүч;

2.2.3.2. Тэргүүн түрүүч.

2.3. Цол олгох эрх бүхий албан тушаалтан онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг албан тушаалтанд цол олгохдоо албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг хатуу мөрдлөг болгоно.

2.4. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тусгай албан тушаалд шинээр болон дэвшин томилогдож байгаа албан хаагчид тухайн албан тушаалын ангилалд тохирох цолыг олгох асуудлыг томилогдсоноос нь хойш 12 сарын дотор шийдвэрлэнэ.

2.5. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын тухайн тусгай албан тушаалд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчид албан тушаалын цолны зэрэглэлээс нэг шат дээгүүр цол олгож болно.

Гурав. Цол бууруулах

3.1. Цол олгох эрх бүхий албан тушаалтан тусгай албан тушаал эрхэлж байгаа албан хаагчийн албан тушаалын цолыг бууруулна.

3.2. Албан тушаал буурч томилогдсон албан хаагчийн цолыг бууруулж, тухайн албан тушаалын зэрэглэлийн цолыг олгоно.

3.3. Байгууллагын орон тооны өөрчлөлт, ажлын зайлшгүй шаардлагаар албан тушаалын цолны нэг зэрэглэл доогуур албан тушаалд томилогдож байгаа албан хаагчийн цолыг бууруулахгүй байж болно.

3.4. Албан үүргээ биелүүлээгүй, төрийн албаны ёс зүйг зөрчсөн, ажлын хариуцлага алдсан албан хаагчийг албан тушаал бууруулан томилохгүйгээр бол түүний цолыг 12 сар хүртэл хугацаагаар нэг шатаар бууруулж болно.

2005 оны 3 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2005-2006 оны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Байгаль орчны сайд У.Барсболдод даалгах нь:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах менежментийг зөв сонгож ойжуулалтын, усны зэрэг байгаль-экологийн бусад хөтөлбөр, гадаргын усны нөөц, чийгийг нэмэгдүүлэх санал, санаачилгатай нягт уялдуулж байсугай;

б/тухайн бүс нутгийн байгаль орчинд ургах, амьдрах чадвартай орон нутгийн болон гадаадын бусад орнуудад ургадаг мод, бут, сөөг, ургамлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан тогтоон ашиглаж "Ногоон хэрэм" хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх арга хэмжээг байнга авсугай;

в/говь, хээрийн бүсэд "Ногоон хэрэм" байгуулах мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран шийдвэрлэсүгэй;

г/хандивын тоглолт хийлгэх, сугалаа гаргах зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах замаар "Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсугай;

д/"Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар гадаад, дотоодод уулзалт, семинар зохион байгуулж гадаад орон, олон улсын, түүний дотор Азийн бүс нутгийн хүч, хөрөнгийг энэ ажилд татан оролцуулах арга хэмжээ авч байсугай;

е/цөлжилт, элсний нүүлтийг сааруулах чиглэлээр гадаад, дотоодод хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж нэвтрүүлэх, энэ чиглэлээр гарч байгаа санал санаачилгыг дэмжиж ажилласугай;

ж/Монгол Улсын заган ойн санд үзлэг хийж, түүний нөөц, эзлэх талбайн хэмжээг бодитойгоор тогтоох арга хэмжээг 2007 онд багтаан авч хэрэгжүүлсүгэй;

з/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах

үүрэг бүхий "Ногоон хэрэм" сан байгуулах, уг хөтөлбөрийн удирдах зөвлөлд туслах болон сангийн үйл ажиллагааг зохицуулах алба бий болгох асуудлыг зохих журмын дагуу зохицуулан шийдвэрлэсүгэй.

3. Байгаль орчны сайд У.Барсболд, Сангийн сайд Н.Алтанхуяг, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/"Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ойн санг нэмэгдүүлэх, ойг нөхөн сэргээх, хамгаалах, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах арга хэмжээний санхүүжилтэд хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн болон төсвийн хөрөнгийг ашиглах арга хэмжээ авсугай;

б/говь, хээрийн бүсэд тарих мод, модлог ургамлын үр, тарц, суулгацаар бүсчилэн хангах үүрэг бүхий мод үржүүлгийн газрыг бэхжүүлэх, байгуулах асуудлыг 2006 онд багтаан шийдвэрлэсүгэй.

4. Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгах нь:

а/байгалийн нөөц ашигласны төлбөрийг ялгавартайгаар тогтоох, ойжуулалтад оруулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвх санаачилга, хөдөлгөөнийг өрнүүлэх, модны хулгай, хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэх зөрчлийг арилгах эрх зүйн үндсийг бүрдүүлэх арга хэмжээ авсугай;

б/төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийн тодорхой хэсгийг "Ногоон хэрэм" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх талаар холбогдох төсөл боловсруулж 2005 оны Ш улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авсугай;

в/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад "Ногоон хэрэм" байгуулах зориулалтаар газрыг, зохион байгуулалт бүхий иргэдэд гэрээгээр ойн сангийн тодорхой хэсгийг тус тус хариуцуулах, ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах журмуудыг 2005 онд багтаан боловсруулан батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авсугай;

г/“Ногоон хэрэм” санд хөрөнгө төвлөрүүлэх, хуваарилах, захиран зарцуулах журмын төслийг боловсруулан 2005 оны 6 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсүгэй.

5. Барилга барих, төмөр зам тавих, засварлах ажилд өөр төрлийн материал орлуулан ашиглах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар мод, модон материалын хэрэглээг багасгах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаяр, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Г.Батхүү, Байгаль орчны сайд У.Барсболд болон зам, барилгын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч нарт үүрэг болгосугай.

6. Бүх шатны Засаг дарга нарт даалгах нь:

а/“Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд нутгийн иргэдийг өргөнөөр татан оролцуулсугай;

б/малын хашаа хороо барихад чулуу, шавар зэрэг орон нутгийн түгээмэл тархацтай материалыг өргөн ашиглах, малын нөмөр хаалтад зориулан харгана, сөөг, бусад модлог ургамал тарьж хэрэглэх аргыг нэвтрүүлэх үндсэн дээр мод, шургаагнийг хашаа хороонд зориулан бэлтгэх ажлыг зогсоох арга хэмжээ авсугай;

в/бэлчээрийг хуваарьтай, ээлж дараатай ашиглах замаар байгалийг өөрийн аясаар нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч байсугай.

7. Говь, хээрийн бүсэд шахмал түлшний үйлдвэрлэл, эрчим хүчний бусад эх үүсвэрийг ойрын үед шийдвэрлэх чиглэлээр төсөл боловсруулан хэрэгжүүлэх, хот, төв суурин газрын түлээний модны хэрэглээг багасгах арга хэмжээ авахыг Түлш, эрчим хүчний сайд Т.Очирхүү, Байгаль орчны сайд У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

8. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаанд даалгах нь:

а/“Ногоон хэрэм” хөтөлбөр хэрэгжүүлэх бүс нутгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мод, бут, сөөг тарих, ургуулах, арчилж тордох арга барил, анхан шатны мэдлэг эзэмшүүлэх арга хэмжээ авч байхын зэрэгцээ тэдгээрийг 2007 онд багтаан туршлагын мод үржүүлгийн талбайтай болгосугай;

б/хот цэцэрлэгжүүлэлт, цөлжилттэй тэмцэхэд зориулан биотехнологийн аргаар модлог болон бусад ургамлын тарьц, суулгац ургуулах хүлэмж, цех байгуулах төсөл хэрэгжүүлсүгэй;

в/говь, хээрийн бүсэд мод, бут, сөөг тарих, ургуулах, арчилж тордох эрдэм шинжилгээ,

судалгааны ажилд судлаач, эрдэмтэд, оюутнуудыг өргөнөөр татан оролцуулж байсугай;

г/“Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, монгол орны ойн санг хамгаалах, ойжуулах, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах талаар төр, засгаас явуулж байгаа бодлого, ач холбогдлыг тусгаж, нийтэд сурталчлах арга хэмжээ байнга авч байсугай.

9. Байгаль орчны сайд У.Барсболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан, Хууль зүй, дотоод зэргийн сайд Ц.Нямдорж, Батлан хамгаалахын сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, бүх шатны Засаг дарга нарт даалгах нь:

а/аж ахуйн нэгж, байгууллага, зэвсэгт хүчин, хилийн цэрэг, төрийн бус байгууллага, нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг, оюутан, сурагч, иргэд, хамтлагт “Ногоон хэрэм” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой газар нутгийг хариуцуулан ажиллуулахын зэрэгцээгээр энэ ажилд оролцох гадаад орон, олон улсын байгууллагын үүсгэл санаачилгад идэвхтэй дэмжлэг үзүүлж ажилласугай;

б/гадаад, дотоодын албан ёсны томоохон арга хэмжээ, бүх шатны сургуулийн элсэлт, төгсөлт, цэрэг таталт, халалт, иргэдийн хуримын болон андгай өргөх ёслол зэрэг арга хэмжээний үед хот, төв суурин газарт мод тарих уламжлалыг 2005 оноос эхлэн хэвшүүлсүгэй;

в/“Ногоон хэрэм” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ойжуулалтын ажилд цэргийн дүйцүүлэх алба хаагчид, хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийг өргөнөөр татан оролцуулсугай.

10. Монгол Улсын нутаг дэвсгэрт импортоор оруулж ирсэн мод, модон материалыг боловсруулах, дамжуулан борлуулах аж ахуйн нэгж, сүлжээ байгуулах асуудлыг судалж, шаардлагатай арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд С.Батболдод үүрэг болгосугай.

11. Нийслэл болон хүн ам төвлөрсөн томоохон суурин газруудад үр, тарьц, суулгац борлуулах, байгаль орчны мэдээлэл өгөх төвүүд бий болгох арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Барилга, хот байгуулалтын сайд Н.Батбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**

У.БАРСБОЛД



Засгийн газрын 2005 оны 44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"НОГООН ХЭРЭМ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол орны ойн сан, цөлжилт, элсний нүүдэл, шар шороон шуурганы өнөөгийн байдал

Манай орны ойн сан 18.3 сая га бөгөөд ой модоор бүрхэгдсэн талбай нь 12.9 сая га буюу нутаг дэвсгэрийн 8.2 хувь, үүнээс шилмүүст, навчит ойн талбай нь 10.5 сая буюу 6.7 хувь байгаа бөгөөд энэ үзүүлэлтээр ойн нөөцөөр хомс орны тоонд багтдаг.

1940-2002 онд 45.0 сая шоометр орчим модыг 320 гаруй мянган га газраас бэлтгэж ашигласнаас гадна жилд дунджаар түймэрт 392.5 мянган га, хөнөөлт шавьж, өвчинд 101.1 мянган га ой тус тус өртсөн байна. Зөвхөн 1996-1997 онд 5.0 сая га талбай ой түймэрт өртсөний дотор 500 гаруй мянган га талбайн ой сэргэн ургах чадваргүй болжээ.

Ази тивийн төв хэсэгт оршдог, далай тэнгисээс алслагдсан эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадас багатай, далайн түвшнээс дунджаар 1580 м дээш өргөгдсөн онцлогтой Монгол орны нутаг дэвсгэрийн 42.5 хувийг говь, цөлийн бүс эзэлж байна.

Монгол орон газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, газар нутгийн гадаргын хэв шинж, экологийн тогтолцооны хувьд цөлжилтийн аюулд өртөх нэн эмзэг, чийг дутмаг, хуурай бүс нутагт багтдагийн улмаас ган цөлжилтөд байнга нэрвэгдсээр ирсэн билээ.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур 1.56 хэмээр дулаарчээ. Судалгаанаас үзэхэд манай орны нутаг дэвсгэрийн 25 хувийг хамарсан ган 2-3 жилд 1 удаа, нутгийн 50 хувиас илүү хэсгийг хамарсан ган 4-5 жилд 1 удаа тохиолддог бөгөөд тал хээр, говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 1960 оныхтой харьцуулахад 3-4 дахин нэмэгджээ.

Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан цөлжилтийн үйл явц эрчимжиж мөнх цас хайлах, нуур, гол, горхи ширгэх, бэлчээрийн ургамлын гарц муудах, хөрс, ус давсжих, элэгдэл, эвдрэлд орох, үржил шимээ алдах, элсний нүүлт, хөдөлгөөн ихсэх, байгалийн элдэв гамшгийн давтамж нэмэгдэх зэргээр илэрч байна.

Байгалийн хүчин зүйлээс гадна хүний олон талт сөрөг үйл ажиллагаа цөлжилтийг хурдасгахад ихээхэн нөлөөлж байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд цөлжилт хүчтэй илэрсэн нутгийн талбай 5.4 дахин, маш хүчтэй илэрсэн нутгийн талбай 1.8 дахин нэмэгдсэн байна.

Цөлийн бүсийн элсний үндсэн ургамал болох заган ойг их хэмжээгээр ашигласнаас 125.0 мянган га газрын заг бүрэн устжээ.

2. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, бодит шаардлага

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөр боловсруулах болсон шаардлага, бодит үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлж байна:

а/нийт газар нутгийн 70 орчим хувь нь цөлжилт, элсний нүүлтэд хамрагдаж, говь, хээрийн бүсийн ногоон байгууламжийн хэмжээ, тархац хумигдан экологийн тэнцвэр алдагдаж, улс орны цаашдын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлөх болсон, эдгээр хүчин зүйлтэй тэмцэх талаар багагүй арга хэмжээ авч буй хэдий ч дорвитой үр дүнд хараахан хүрэхгүй байна;

б/дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас улс орны эдийн засаг, нийгмийн амьдрал, хүмүүсийн амьжиргаанд үзүүлэх таагүй нөлөөлөл мэдэгдэхүйц нэмэгдэж, элсний нүүлт, шар шороон шуурга, цөлжилтийн үйл явц асар их зэр хүчтэй болж байгаа өнөө үед түүнтэй тэмцэхэд төрийн бодлогыг эрчимжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

1. Хөтөлбөрийн зорилго

Уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагаанаас шалтгаалж ойн сан хомсдох, цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуурга улам эрчимжиж байгаа экологийн өнөөгийн сөрөг нөлөөллийг багасгаж, цөлжилт, элсний нүүлтийг сааруулах ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгоход байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт тохируулан урт хугацааны турш үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлэх үндсэн дээр Монгол орны говь, хээрийн бүсийн заагийг бүрэн хамарсан ногоон зурвас, ногоон төгөл байгуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2. Хөтөлбөрийн үндсэн зорилт
Хөтөлбөрийн үндсэн зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна:

а/говь, цөлийн бүсийн модлог, сөөглөг, өвслөг ургамлын бүрдэл, тархац, биомасс, усан хангамж, хөрсний бүтэц, уур амьсгалын холбогдолтой экосистемийн иж бүрэн судалгаа зохион явуулж хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний шинжлэх ухааны үндэслэл боловсруулах;

б/говь, хээрийн бүсийн заагт элсний нүүлт, цөлжилтийг сааруулах зорилгоор мод, бут, сөөг, ургамлын бүрхэвч бүхий үндсэн "Ногоон хэрэм" буюу "Экотрасс", туслах ногоон зурвас байгуулах;

в/говь, хээр, цөлийн бүсэд ойн нөөц, бэлчээр, тариалангийн талбай, авто болон төмөр замын хамгаалах ногоон зурвас байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх;

г/цөлжилт, элсний нүүлт, шар шороон шуургыг сааруулахад бүх нийтийн оролцоог хангах;

д/ой, ургамлыг нөхөн сэргээх;

е/үндэсний болон орон нутгийн түвшинд "Ногоон хэрэм" байгуулах талаар эрх зүй, зохион байгуулалтын орчныг бүрдүүлэх.

3. Хэрэгжүүлэх үе шат

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааг дараахь гурван үе шаттай байхаар тодорхойлж байна:

I ҮЕ ШАТ /2005-2015 он/-нд хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалт, үндэсний чадавхийг бүрдүүлсний үндсэн дээр нийт ажлын 20-иос доошгүй хувийг гүйцэтгэж, хэрэгжүүлэх арга, технологийг эзэмшинэ;

II ҮЕ ШАТ /2015-2025 он/-нд эхний үе шатныг үйл ажиллагааны явц, байдалд үнэлэлт дүгнэлт өгч, үндэсний чадавхийг бэхжүүлсний үндсэн дээр нийт ажлын 30-аас доошгүй хувийг гүйцэтгэж, үр дүнг сайжруулна;

III ҮЕ ШАТ /2025-2035 он хүртэл/-нд хөтөлбөрийн экологи, нийгэм, эдийн засгийн үр дүнг дээшлүүлж, цөлжилт, элсний нүүлтийн сөрөг нөлөөллийг бууруулах арга механизмыг бүрэн ашигласны үндсэн дээр нийт ажлын 50-иас доошгүй хувийг гүйцэтгэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат бүрт хөтөлбөрийн зорилго, ач холбогдол, хүрэх үр дүн, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн оролцоог олон нийтэд ойлгомжтой байдлаар тайлбарлан сурталчлах, сургалт зохион байгуулах, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь тэргүүн зэргийн асуудал байна.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

а/хөтөлбөр нь ойг нөхөн сэргээх эрх зүй, нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны удирдлагын тогтолцоонд уялдааг эсхэлцэж, цөлжилтийн эрч, элсний нүүлтийг сааруулах ажлыг экологийн хувьд тогтвортой, эдийн засгийн хувьд

ашигтай байх зарчмыг баримтлах, төвлөрлийг сааруулах, говь, хээрийн бүс нутгийн хөгжлийг дэмжих, салбар дундын уялдаа холбоог сайжруулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд, төрийн болон төрийн бус байгууллааг, аж ахуйн нэгжийг өргөнөөр оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, тэдний хувь нэмрийг хөхиүлэн дэмжих хөшүүрэг бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараахь үйл ажиллагааг явуулна:

1 дүгээр зорилтын хүрээнд:

Хөтөлбөр хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулах үйл ажиллагааны хүрээнд:

а/говь, цөл, хээрийн бүсийн экосистемийн талаархи эрдэм шинжилгээний ажлын үр дүнг нэгтгэн дүгнэж мод үржүүлгийн газар байгуулах;

б/агаар, сансрын гэрэл зураг, газрын судалгааны аргаар экосистемийн иж бүрэн онцлогийг тогтоох явуулын ба суурин судалгаа зохион байгуулж хөрс, ургамал, усны нөөцийг тогтоон экотрассын ногоон байгууламжийн эхний газар, талбайг сонгох;

в/говь, цөл, хээрийн бүсийн модлог, бутлаг ургамлын тарьц, суулгацыг биотехнологийн аргаар үржүүлж ашиглах судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэх.

2 дугаар зорилтын хүрээнд:

Үндсэн "Ногоон хэрэм" буюу "Экотрасс", туслах ногоон зурвас байгуулахад дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Монгол орны говь, хээрийн бүсийн заагт баруунаас өмнөд зүгийг холбосон элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах ногоон зурвас үндсэн "Ногоон хэрэм" буюу "Экотрасс"-ын зурвасын өргөн нь 600 метрээс доошгүй, урт нь 2500 км-ээс дээш, талбайгаараа 150.0 мян.га-гаас их байх ба байршлын хувьд говь, цөл, тал хээрийн бүсэд орших Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын зарим нутгийг хамруулсан байна (Хөтөлбөрийн 1 дүгээр хавсралт).

Монгол орны говийн болон хээрийн бүсэд босоо тэнхлэгийн баруунаас зүүн өмнөд зүгийг чиглэсэн элсний нүүлт, цөлжилтөөс хамгаалах туслах ногоон зурвасын өргөн нь 430 метрээс доошгүй, урт нь 1200 км-ээс дээш, талбайгаараа 50.0 мян.га-гаас их байхаар байгуулах бөгөөд

байршлын хувьд говь, цөл, тал хээрийн бүсэд орших Баян-Өлгий, Увс, Хөвд, Завхан, Булган, Төв, Дорноговь аймгуудын болон Улаанбаатар хотын зарим нутгийг хамруулсан байна.

3 дугаар зорилтын хүрээнд:

Хөтөлбөрт тусгагдсан хамгаалалтын ногоон зурвас байгуулах үйл ажиллагааны хүрээнд:

а/говь, цөл, хээрийн бүсэд заг болон бусад навчит ойн нөөц, бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах ногоон зурвас байгуулах үйл ажиллагааг өргөжүүлэх;

б/“Ногоон хэрэм” байгуулах бүс дэх олон улс, улсын чанартай авто ба төмөр замын хоёр талаар хамгаалалтын ногоон зурвас байгуулах.

4 дүгээр зорилтын хүрээнд:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулна:

а/мод, сөөг, олон наст ургамал тарьж ургуулах талаар төв, орон нутгийн холбогдох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх;

б/“Ногоон хэрэм” байгуулах талаар сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

в/бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, хувийн сектор, иргэдийн оролцоог дээшлүүлэх;

г/цөлжилтөд нэрвэгдсэн нутгийн хүн амын нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэхэд хөтөлбөрийн үйл ажиллагаагаар дамжуулан дэмжлэг үзүүлэх;

д/олон нийтийг татан оролцуулах эдийн засгийн урамшууллын оновчтой механизмыг судалж нэвтрүүлэх.

5 дугаар зорилтын хүрээнд:

Хөтөлбөрийг дэмжих хүрээнд ойг нөхөн сэргээх практик арга хэмжээг хэрэгжүүлэх:

а/говь, цөлийн бүсийн доройтсон экосистемийн байршил нутгийг улс, орон нутгийн тусгай хамгаалалтад авах;

б/цөлжсөн нутагт мод, сөөг тарих, говь, цөлийн бүсэд шинээр мод уржүүлгийн газар, талбай байгуулах замаар говь, хээрийн бүсэд ойжуулах ажлын цар хүрээг нэмэгдүүлэх;

в/мод, шургаагаар малын хашаа, хороо барих ажлыг үе шаттайгаар халж ширэг, чулуу, шавар зэрэг байгалийн түгээмэл тархацтай материалаар орлуулах буюу харгана зэрэг мод, сөөг тарьж ургуулах замаар хаалт, номер хашаа хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

г/“Ногоон хэрэм”-ийн дагуу тодорхой зайд түүний арчилгаа, хамгаалалтын нэгж байгуулж ажиллуулах.

6 дугаар зорилтын хүрээнд:

“Ногоон хэрэм” байгуулах эрх зүй, зохион байгуулалтын орчныг бүрдүүлэхэд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох;

б/иргэдэд тодорхой хэсэг газарт ногоон зурвас байгуулахад зориулж хөнгөлөлттэй зээл олгох, ойжуулсан талбайн ургалтын байдлын үр дүнгээр ойн санд шилжүүлэх, уг талбайг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, өмчлүүлэх эрх зүйн орчныг үе шаттай бий болгох;

в/хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар дундын болон орон нутгийн удирдлагын чадавхи, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг бий болгох.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

1. Удирдлага, зохион байгуулалт

а/хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах үүргийг Удирдах зөвлөл хэрэгжүүлэх бөгөөд бус нутаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, багийн түвшинд тухайн шатны салбар зөвлөлүүд тус тус хариуцна;

б/хөтөлбөрийн Удирдах зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд ахлаж, гишүүдэд Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд урд өмнө ажиллаж байсан иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, салбар зөвлөлийг тухайн шатны Засаг дарга ахлаж, гишүүдэд орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл тус тус орсон байна. Хөтөлбөрийн удирдах зөвлөл нь ажлын албатай байж болно;

в/хөтөлбөрийн хэрэгжилтэд олон нийтийн хяналт, шилжилгээ хийх үйл ажиллагааг хариуцдаг төв, орон нутгийн хяналтын зөвлөл ажиллана;

г/хөтөлбөрийн хяналтын зөвлөлийг Байгаль орчны сайд ахлаж, бүрэлдэхүүнд нь Байгаль орчны сайдын албан тушаалд урьд өмнө ажиллаж байсан иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөл орсон байна. Орон нутгийн хяналтын зөвлөлд тухайн шатны төр, засгийн байгууллагад удирдах албанд ажиллаж байсан иргэд, байгаль орчны албаны удирдлага, байгаль орчны байцаагч болон орон нутгийн иргэдийн үүсгэл санаачилгын ба аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл тус тус орсон байна.

2. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

б/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө;

в/байгууллага, аж ахуйн нэгжийн хөрөнгө;

г/иргэдийн хандивын хөрөнгө;

д/байгаль хамгаалах сангийн хөрөнгө;

е/бусад.

Хөтөлбөрийн санхүүжилтийг оновчтой болгох үүднээс түүнийг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив болон бусад эх үүсвэрээр хуримтлагдсан хөрөнгөөр "Ногоон хэрэм" сан байгуулж болно ("Ногоон хэрэм" хөтөлбөрийн нийт зардлын хэрэгцээ, үүнээс эхний үе шатны зардлын хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр хөтөлбөрийн 2 дугаар хавсралтад үзүүлэв).

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга зам, хамтын ажиллагаа

1. Хэрэгжүүлэх арга зам

а/хөтөлбөрийн үе шат бүрээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газрын шийдвэрээр батлуулж, жил бүр хэрэгжүүлэх арга хэмжээг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган зохион байгуулна;

б/говь, хээр, цөлийн бүсэд мод, соёг, ургамал тарих, хамгаалалтын зурвас байгуулах загварын үндсэн дээр нутгийн иргэд, сум, аймаг болон аж ахуйн нэгж, байгууллага тус бүр тухайн газар орчны өвөрмөц байдалд тохирсон төсөл, арга хэмжээний саналыг боловсруулж, холбогдох журмаар шалгаруулан хэрэгжүүлнэ ("Ногоон хэрэм" үндсэн болон туслах зурвасны бүдүүвч зургийг хөтөлбөрийн 3, 4 дүгээр хавсралтуудад үзүүлэв);

в/орон нутгийн хөрс, усны онцлог тохирсон мод үржүүлгийн газруудыг байгуулж үр, мөчир, тарьц, суулгац бэлтгэхээс гадна одоо үйл ажиллагаа явуулж байгаа мод үржүүлгийн газруудыг бэхжүүлэх замаар болон гадаад орнуудаас худалдаж авах замаар тарьц, суулгацын материалаар хангана. Үүнд: улиас, бургас, хайлаас, заг, чацаргана, харгана, жигд, тоорой, сухай болон олон наст ургамал орно;

г/"Ногоон хэрэм"-ийн байршилд ойр сум, аймаг, орон нутгийн хөдөлмөр эрхлээгүй ард иргэд, оюуган сурагчид, малчдыг татан оролцуулж мэргэжлийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг түшиглэх замаар хэрэгжүүлнэ;

д/хөтөлбөрийн хүрээнд ойжуулсан талбай, ойн зурвасыг иргэд, аж ахуйн нэгжид урт хугацаагаар гэрээгээр эзэмшүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх арга замаар хэрэгжүүлнэ;

е/говь, хээрийн бүсийн ойжуулалт, мод үржүүлгийн ажлын тарьц ургуулах агротехник, техник, технологийг боловсронгуй болгож, энгийн, бага оврын техник, хэрэгслээр хангана;

ж/гадаад орнуудад хөтөлбөрийг сурталчилж, олон улсын тусламж, дэмжлэгийг авах ажлыг өрнүүлнэ.

2. Хамтын ажиллагаа

а/гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулах, хамтран хэрэгжүүлэх төслийн баримт бичигт ногоон зурвас байгуулах, говь, хээрийг ойжуулах талаар тусган хэрэгжүүлнэ.

б/НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага, Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцийн гишүүн орнууд, НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд, шар шороон шуурганы талаар Азийн бүсийн төвтэй харилцан хамтран ажиллах боломжийг ашиглана.

Долоо. Гарах үр дүн, түүнийг тайлагнах

1. Гарах үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр Монгол орны ойн талбай 1.6 хувиар нэмэгдэж, говь, хээрийн бүсийн экосистемд зөрөг өөрчлөлтүүд гарна. Цөлжилт, элсний нүүлтийн эрч саарч, бэлчээрийн даац нэмэгдэж, бүс нутаг, улс орон, олон улсын хэмжээнд шороон шуурганы сөрөг үр дагавар буурна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүсэд улирлын чанартай 20.0 мянга орчим хүний шинэ ажлын байр бий болж, өрхийн орлого нэмэгдэн ядуурлын түвшин буурна.

Мод, сөөгний үр, жимс, жимсгэнэ, мөчир, тарьц, суулгацыг ашиглах замаар орлогын шинэ эх үүсвэр бий болж, нутгийн иргэд түүний үр шимийг хүртэх тогтвортой хөгжлийн хүчин зүйл бий болно. Говь, хээрийн бүсийн заган ойн нөөц хамгаалагдаж, навчит ойн талбай нэмэгдэж, байгаль, цаг уурын тохиромжтой нөхцөл бий болж, экологийн тэнцвэртэй байдал хадгалагдана. "Ногоон хэрэм" хөтөлбөр хэрэгжсэнээр говь, хээрийн бүсийн таримал ой, ойн зурвасын эрх зүйн орчин боловсронгуй болно. Говь, хээрийн бүсийн онцлог тохирсон суулгац, үр, тарьцын нөөцтэй болно.


2. Хөтөлбөрийн үр дүнг тайлагнах

Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хянах, дүгнэх тусгай шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 2 жилд нэг удаа тайлан гаргаж Засгийн газарт танилцуулж байхыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

"Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн 1-р хавсралт

МОНГОЛ ОРНЫ ГОВЬ ХЭЭРИЙН БҮСЭД БАЙГУУЛАХ

НОГООН ХЭРЭМ



ТАНИХ ТЭМДЭГ

- Ногоон хэрэм
- Үндэсн зураас
- Туслах зураас
- Аймагийн хил
- Сумын хил
- Аймгийн төв
- Сумын төв
- Нуур
- Гол, мөрөн

- Ногоон тал тогтоогдсон газрын дотор ус
- Усны нөөцийн цогцолбор 2005-2025 он
- Ойн тархалт
- Шилжүүст нэгжт ой
- Зар

200 0 200 Kilometers

Зургийг БОР-ын Ой, Усны хэлтэс
сүлдэгдэнтэйгээ болгосруулав.
2005 он.

А. "НОГООН ХЭРЭМ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН НИЙТ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Гүйцэтгэх ажил	Хэмжих нэгж	Бүгд	1-р үе шат	2-р үе шат	3-р үе шат
1	"Ногоон хэрэм"-ийн нийт урт	км	3700	750	1100	1850
2	Байгуулах "Ногоон хэрэм"-ийн талбай	мян.га	200.0	40.0	60.0	100.0
3	Нэг га "Ногоон хэрэм" байгуулах талбайн технологийн картын дагуу тооцсон дундаж зардал	мян.төг	-	880.0	950.0	1100.0
4	"Ногоон хэрэм" байгуулахад шаардагдах нийт зардал (нэгжийн дундаж зардлаар тооцсоноор)	сая.төг	204250.0	35200.0	57950.0	111100.0


Б. "НОГООН ХЭРЭМ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

(Санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, сая.төг)

Д/д	Хугацаа	Санхүүжүүлэх эх үүсвэр				Бусад	Нийт сая.төг
		Улсын төсвөөс	Гадаадын хандилагч орны дэмжлэгээр	Аж ахуйн нэгж, байгууллагын хандив	Байгууллагын хандив		
		3525.0	8460.0	1410.0	705.0	14100.0	
	2005-2010 он, бүгд	400.0	1200.0	166.0	84.0	1850.0	
1	Үүнээс: 2005 он	500.0	1200.0	200.0	100.0	2000.0	
	2006 он	5280.0	12672.0	2112.0	1036.0	21100.0	
2	2010-2015 он, бүгд						

“НОГООН ХЭРЭМ” үндэсний хөтөлбөрийн 3-р хавсралт


“НОГООН ХЭРЭМ” үндсэн зурвасны бүдүүвч зураг



Таних тэмдэг

- Улиас
 - Хайлаас
 - Гүйлс / Чацаргана
 - Хуяйс / Бургас
 Эгнээ хоронд 4м, Мод хооронд 3м

“Ногоон хэрэм” туслах зурвасны бүдүүвч зураг



Таних тэмдэг

- Улиас
 - Хайлаас
 - Гүйлс/Цацаргана
 - Хуяйс / Бургас
 Эгнээ хоронд 4м, Мод хооронд 3м

Засгийн газрын 2005 оны 44 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

"НОГООН ХЭРЭМ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2005-2006 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Гүйцэтгэх хугацаа	Хэрлүүцэх эзэн
1	"Ногоон хэрэм" хөтөлбөрт хамрагдах газрын байршилсыг судлах сэдэр зүй, геоэкологийн судалсааны бас ажиллуулах, хэрэм байгуулах технологийг, арга хэлбэрийг нарийвчлан тогтоох, экосистемийн онцлогийг харгалзан тэрхж урсуулах мод, модлог урсгалын нэр төдийг сонсох	2005	БОЯ, ШУА
2	"Ногоон хэрэм" хөтөлбөр хэрэгжүүлэх үндэсний болон орон нутгийн зөвлөл, нэгжүүдийг зохион байгуулах, хөтөлбөрийн удирдах зөвлөлийг орон түүний элбэлэй болгох, нутгийн ирээд, байгууллагын саналын дагуу хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг боловсруулах	2005-2006	БОЯ, СЯ, аймags, нийслэлийн Засгас даргас
3	"Ногоон хэрэм" үндсэн эхотрасын дагуу усны хабсуул судалгаа хийж, уст цэсүүдийг тогтоох, усжуулах асуудлыг шийдвэрлэх	2005-2006	БОЯ, ШУА
4	"Ногоон хэрэм" хөтөлбөрийг сабаад улс оронд сурталчилгах зорилгоор хандиелгасчдын уулзалт зохион байгуулах	2005 оны III улирал	БОЯ, ГХЯ
5	Хөтөлбөрт оролцох ирээд олон нийтийн байгууллагуудын дунд сэдвэчилсэн сургалт зохион байгуулах	2005 оны II -IV улирал	БОЯ, БСШУЯ
6	Ховд, Дорноговь, Сүхбаатар, Бөвөрхангай, Төв аймсуудад мод уржуулсийн сэдэр байгуулах	2005 -2006	БОЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
7	Хөтөлбөрт хамрагдах бус нутагт тохиромжтой хүрдэн урсах, амьдрах чадвар сайтай мод, модлог урсгалын ур, тарыг суулгагчсаг сабаад, ботгоодын зах зээлээс олж нийлүүлэх ажлыг зохион байгуулах	2005 -2006	БОЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
8	"Ногоон хэрэм" зургаасын холбогдох хэсгийг сабаадын хандиелгасч, улсын төсөв, орон нутгас, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүч хөрөнгөөр тус тус хэрэгжүүлэх хуваарийг нарийвчлан гэрсаж мөрдүүлэх	2005 оны I-II улирал	БОЯ, СЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
9	Улсын төсөв, сабаадын санхүүжилтээр хэрэгжүүлэх томоохон төсөл, арга хэмжээг төндөр гэрлэх, гүйцэтгэсчид сонсон шалсаруулж санхүүжүүлэх	2005-2006	БОЯ, СЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
10	БНХАУ болон бусад орнуудад хэрэгжүүлж буй ижил төстэй ажлын туршилагыг судалж, нэйтүүлэх	2005 -2006	БОЯ, ГХЯ, СЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
11	Ойжуулалт, мод уржуулсийн ажилд дэвшилтэт технологи нэйтүүлж, шаардагдах томог төлөв рөмжөөр хансах	2005-2006	БОЯ, УХЯ, СЯ, холбогдох аймags, нийслэлийн Засгас даргас
12	"Ногоон хэрэм" хөтөлбөрийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр сурталчилгах ажлыг тогтмолгожуулах	2005-2006	БОЯ, Радио, телевизийн хэрэгс эрлэх сэдэр



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2005 оны 03 дугаар сарын 31-ний өдөр

Дугаар 02/02

Улаанбаатар хот

**Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ж.Амарсанаа, Ч.Дашням /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч С.Магнайсүрэн, мөн дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч Б.Энхбаяр, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэн нар хуралдаанд оролцлоо.

Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6-д Монгол Улсын Засгийн газар, Сонгуулийн ерөнхий хороог Захиргааны хэргийн шүүхийн хянан хэлэлцэх маргааны харъяалалд хамааруулан заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Магнайсүрэн, мөн дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Энхбаяр нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ирүүлсэн байна.

Өргөдөл гаргагчид Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлийг тус тус үндэслэл болгон Үндсэн хуулийн цэцэд хандаж байгаагаа тэмдэглэсэн байна.

Уг өргөдөлд:

"1.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн.

Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д: "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1-д: Засгийн газар нь "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" бүрэн эрхтэй гэж заасан. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд "1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна. 2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана", 45

дугаар зүйлийн 2-т: "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж хуульчилсан.

Энэ нь УИХ, Засгийн газар /бас Үндсэн хуулийн цэц/-аас өөр субъект Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгохгүй гэдгийг шууд тодорхойлсон хэрэг бөгөөд үүнтэй төсөвтэй харилцааг зохицуулсан Үндсэн хуулийн бусад зүйл, хэсгийн заалтаас ч харж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 2-т: "Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж заасан ба энэхүү үзэл баримтлалын дагуу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд Ерөнхийлөгчийн баталсан шийдвэрийг хамааруулаагүй байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 2-т: "Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын Дээд шүүх өөрөө хүчингүй болгоно" гэж заасан байна.

Эндээс үзэхэд Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын Дээд шүүх гэсэн Үндсэн хуульд заагдсан эдгээр байгууллагуудын шийдвэрүүдийг хүчингүй болгохтой холбогдсон дээрх заалтууд нь угтаа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн салаа мөчир тус бүрийн эрх мэдлийн харилцан зааг хязгаар, хариуцлагыг тогтооход чиглэгдсэн байна.

2.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д: "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" гэж заасан. Сонгууль бол төлөөллийн ардчилал, улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт байдлын баталгаа, иргэний сонгох, сонгогдох эрхийн илэрхийлэл мөн.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад Үндсэн хуулийн цэцээс хянан шийдвэрлэх маргааны нэг төрөл болгон "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцжэ байгаа эсэх"-д Үндсэн хуулийн цэц хяналт тавихыг оруулж заасан нь нэг талаас, Монгол Улсын иргэний

снгуулийн /сонгох, сонгогдох/ буюу тус Улсын Үндсэн хуулиар олгосон улс төрийн эрхийг Үндсэн хуулийн эрх зүйн өндөр төвшинд хамгаауулах бломжийг Монгол Улсын иргэдэд олгох; нөгөө таваас, Монгол Улсын төрийн эрх барих болон буад дээд байгууллагыг сонгож байгуулах, түүний нитийг засаглах дээд эрх мэдлийн хууль ёсны шэнжийг хүлээн зөвшөөрүүлэхтэй холбоотой.

Сонгуулийг зохион явуулах үүргийг сонгуулийн байгууллагууд хариуцах ба сонгуулийн хуль тогтоомжийн биелэлтийг улс даяар зохион багуулж хангах үүрэгтэй сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн үнэн зөв, эргэлзээгүй бадлаас хамаарч нийт сонгогчдын хүсэл зориг шударгаар илэрхийлэгдэж чадах эсэх нь тодорхойлогдох, сонгуульд оролцогч бусад этгээдийн эрх зүйн байдал /статус/-д өөрчлөлт орсод хүргэдэг, мөн сонгуулийн баталгаажсан үр дүнээр засаг төрийн тогтвортой залгамж чанар хадалагдах, үндэсний эв нэгдэл хангагдах, хууль тогтох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг хууль ёсоор эмхлэн байгуулах зэрэг төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх үндэс болж байдаг. Ийм ч учраас Үндсэн хуулийн үзэг баримтлалд сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна.

Манай улсын хууль тогтоомжоор өдгөө сонгуулийн байгууллагууд захиргааны журмаар сонгуулийн маргааныг хянан шийдвэрлэж байгаагаас гадна сонгуулийн тодорхой зөрчилтэй буюу сонгуулийн өмнөх ухуулга сурталчилгааны журам зөрчсөн зэрэг хэргүүдийг захиргааны шийтгэл ногдуулах журмаар ердийн шүүхийн шүүгч хяналт тавьж хариуцлага хүлээлгэдэг, харин сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар гомдлоо хэргийн хороонд гаргаад, гаргасан шийдвэрийг нь эс зөвшөөрөөл шууд ердийн шүүхэд хандаж, иргэний процессын журмаар шийдвэрлүүлдэг бол сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тусгай журмаар хянан үзэх эрх зүйн журам үйлчилж байна.

Гэтэл Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтаар Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргааны хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хамааруулснаар Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйн харилцаанд оролцогч сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, сонгуульд оролцогчоо Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор илэрхийлж бүртгүүлсэн нам, эвсэл зэргийн хооронд үүсч болох нийтийн эрх зүйн аливаа маргааныг нь захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг олгосон байна.

Энэ нь нэгд, сонгуулийн төв байгууллага ба сонгогч, нэр дэвшигч, нэр дэвшүүлсэн нам, эвслийн Үндсэн хуулийн эрх зүйн статусыг хөндсөн, хобрт, сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцсэн байхад ч тодорхой нэгэн этгээдийн эрх ашигт нийцүүлж уул шийдвэрийг хүчингүй болгож байх бүрэн эрхийг захиргааны хэргийн шүүхэд олгосон, гуравт, сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянан үзэх талаарх халдашгүй байдлын хүрээг ийнхүү

хумиснаар хэн боловч өөрийн эрх зөрчигдсөн нэрийдлээр сонгуулийн байгууллагын хууль ёсны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлж зогсоох, сонгуульд оролцогчдын хоорондох зөрчилдөөнийг хурцатгах, сонгуулийн дараа ч гэсэн шүүхийн арга замаар ялах "горьдлого" төрүүлэх, шүүхийн процесст сонгуулийн байгууллагууд нэг нэгнийхээ эсрэг нотлох баримт гаргах, хэргийн аль нэг талд гэрчээр оролцох зэргээр "ажиллах", мөн сонгуулийн байгууллагууд шат шатандаа захиргааны урьдчилан шийдвэрлэх журмаас болж олон гомдол, өргөдөлд дарагдаж сонгуулийг богино хугацаанд багтааж шийдвэрлэж чадахгүй байх, шийдвэрлэсэн ч шүүхээс түүнийг тухай бүр өөрчлөх, эсхүл сонгууль зохион явуулах үндсэн үүргээсээ хазайж хөрөнгө хүч, цагийг маргаан шийдвэрлэхэд зориулах, түүнчлэн шүүх олон нэхэмжлэлд дарагдаж, сонгуулийн маргаантай хэргүүдийг шийдвэрлэх явц хэт сунжрах, үүний улмаас сонгуулийн үр дүн хуульд заасан хугацаанд гарахгүй байх, сонгогчдын эрх хохирох байдалд хүрэхэд дээрх Үндсэн хуулийн бус заалтын сөрөг үр дагаврууд түлхэж байна.

Мөн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг үндэслэн Нийслэлийн захиргааны хэргийн шүүх Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг хянан үзэж байгаа нь ч хууль зүйн хяналтын статус, төвшний хувьд илтэд тохирохгүй байна. Ийм жишг практик ч олон улсад байдаггүй. Хэрэв Үндсэн хуулийн цэцээс гадна бусад шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг хянаж байх ёстой гэж үзвэл Улсын Дээд шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийн заримыг хууль зүйн агуулга, эрх зүйн маргааны шинж онцлогийн хувьд Үндсэн хуулийн эрх зүйн бус маргаан бол хуулиар нарийвчлан тодорхойлсон нөхцөлд хянаж шийдвэрлэж байх нь Үндсэн хуулийн хяналтаас тусгаарлах үндэслэл болох ёстой.

Үүнээс гадна захиргааны хэргийн шүүх сонгуулийн төв байгууллагын шийдвэрийг нэхэмжлэлийн дагуу хүлээн авч хянан үздэхдээ Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмыг мөрдсөн байхыг Сонгуулийн ерөнхий хорооноос шаардхаар хуульд заагдсан байгаа. Гэтэл нөгөө талаар сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэцэд хянагдах бол захиргааны хэрэг бус Үндсэн хуулийн маргаантай хэрэг болдог.

Өөрөөр хэлбэл, Сонгуулийн ерөнхий хороо заавал Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх албагүй мэт. Тэгэхээр нэг бол сонгуулийн төв байгууллагын аливаа шийдвэрийн талаар Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүхийн алинд нь ч нэхэмжлэл очихыг үл харгалзаж гарсан маргааныг Сонгуулийн ерөнхий хороо "захиргааны хэрэг" мэт үзэж сонгуулийн хуулиас гадна Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар урьдчилж шийдвэрлэж байх, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар гомдол гаргагч Үндсэн хуулийн цэцэд эхэлж "зарга" мэдүүлж, дараачаар нь Үндсэн хуулийн цэцийн харъяаллын маргаан бус байвал сая Захиргааны хэргийн шүүх шийдвэрлэж байх гэж мэт Үндсэн хуулийн цэц, захиргааны хэргийн шүүх хоорондын маргааны харъяалал, шалгуур журмыг тодотгож

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тогтоож өгөөгүй нь Захиргааны хэргийн шүүхэд Үндсэн хуулийн маргаан мөн эсэхийг тодорхойлох боломжийг олгож байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн практикаас үзэхэд Сонгуулийн ерөнхий хорооны УИХ-ын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг Нийслэлийн захиргааны хэргийн шүүх хянан шийдвэр гаргаж байна. Жишээ нь, УИХ-ын сонгуулийн 24, 59 дугээр тойргийн сонгуулийн дүн, дахин санал хураалттай холбоотой маргааныг энд дурдаж болно. Хэрэв уг маргаан Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй бол Сонгуулийн ерөнхий хорооны өөр ямар ч шийдвэр Үндсэн хуулийн цэцээр хянагдахгүй гэдэг нь тодорхой.

Сонгуулийн ерөнхий хорооны УИХ-ын гишүүнийг сонгох сонгуулийн үр дүнтэй холбогдуулан гаргасан шийдвэр хууль зүйн агуулгаараа ч тэр, Үндсэн хуулийн үндэслэлээр ч тэр Үндсэн хуулийн цэцийн хяналтын шууд объект болж чадна.

Сонгуулийн ерөнхий хорооны тухайн шийдвэр нь зөвхөн тодорхой нэгэн хувь этгээдийн эрх ашгийг хөндсөн, түүнд холбогдох асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн захиргааны байгууллагаас гаргасан нэг удаагийн чанартай захирамжлсан акт төдий биш учраас Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэрүүд нь өргөн утгаараа сонгогчийн субъектив эрх, нэр дэвшигч болон түүнийг дэвшүүлсэн нам, эвслийн эрх ашиг, сонгуулийн объектив дэг журмыг хамгаалах нийтийн ашиг сонирхлын зүй ёсны шаардлага, үндэсний эв нэгдлийг хангах зэргийг бодолцож хууль ёс, зүй ёсны дагуу гарах ёстой шийдвэрүүд байдаг.

Чухамдаа эдгээр шийдвэрийг Үндсэн хуулийн заалт түүний үзэл санааны дагуу Цэц л авч үзэж залруулж, нийгэм-төрийн үйл ажиллагаанд ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчмыг чандлан сахиулах учиртай.

Эдгээрийг харгалзан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.6 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дочин тавдугаар зүйлийн 2, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад нийцээгүй болохыг магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье" гэжээ.

Мөн өргөдөл гаргагч иргэн С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн тайлбартай холбогдуулж нэмэлт тайлбар ирүүлсэн бөгөөд уг тайлбартаа: "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2 дахь заалтын "Ерөнхий сайд" гэсэн нь мөн хуулийн 4.1.1 дэх заалтын адил Үндсэн хуулийн Дочин тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцээгүй байгаа тул уул асуудлыг өмнө гаргасан хүсэлтийн хүрээнд магадлан шийдвэрлэж өгөхийг хүсье. Учир нь Ерөнхий сайдын шийдвэр /захирамж/ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1,

Дочин нэгдүгээр зүйлийн 1, Дочин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрын шийдвэрт хамаардаг юм. Гэтэл Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайдын шийдвэрт хамааруулсан нь Үндсэн хуулийн дээр дурдсан заалтуудад шууд харшилж байна" гэж нэмэлт шаардлага тавьсан байна.

Хоёр. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэнтэй холбогдуулж Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцохоор томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбузур, С.Баярцогт нар уг маргаантай холбогдуулж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

"1.Захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан, иргэн, хуулийн этгээдийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн олон тооны шийдвэр гаргаж байгаа боловч практикт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргасан захиргааны актыг хууль зүйн үндэслэлийг хянах механизмыг оновчтой тогтоох зорилгоор Засгийн газраас 2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүн/Ерөнхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Сонгуулийн ерөнхий хороо гэх мэт нийтийн эрх зүйн 17 субъекттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан байв.

Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчөөс эрх зүйн үр дагавар шууд бий болгодог захирамжилсан шийдвэр гаргах явдал бараг тохиолдохгүй мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн "Монгол Улсын Ерөнхийлөгч" гэсэн заалтыг хасч, харин гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болсон Засгийн газрын шийдвэр нь шүүхийн журмаар хянагдаж байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөлд хэвээр үлдээжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дочин тавдугаар зүйлийн 2-ийн "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжийн нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна. Практикт дээр дурдсан журмаар Засгийн газрын тогтоол, захирамжийг хүчингүй болгосон явдал тохиолдохгүй байна.

Нөгөө талаас Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу иргэн, хуулийн этгээд нь захиргааны хууль бус гэж үзэж байгаа актыг талаархи нэхэмжлэлээ захиргааны хэргийн шүүхэд гаргахын өмнө гомдлоо тухайн байгууллага, албан тушаалтны харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтнаар урьдчилан шийдвэрлүүлж байхаар хуульчилсан билээ. Улсын Их Хурал нь гомдол, маргаан хянан шийдвэрлэдэг байгууллага биш учраас иргэн, хуулийн этгээдийн гаргасан гомдлыг хянан баргадуулах боломжгүй юм.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн "төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй", мөн зүйлийн 14-т "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... шударга шүүхээр шүүлэх... эрхтэй" гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн, тухайлбал, Хүний эрхийн тэгээмэл тунхаглалын "Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ дүрэн сэргээн тогтоолгох эрхтэй" гэсэн Наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын "Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгааварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй..." гэсэн Хорин зургадугаар зүйлийн заалтыг баримтлан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газрын гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан.

Хэрэв Засгийн газрын шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх захиргааны хэргийн шүүхийн статус /эрх зүйн байдал, төвшин/ нь тохирохгүй байна гэж үзэж байгаа бол Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасныг баримтлан Улсын Дээд шүүх шаардлагатай гэж үзвэл ямар ч хэргийг татан авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрхтэй билээ. Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Засгийн газраас гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

2. Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээгээр эрхлэн явуулах үүрэгтэй байнгын байгууллага бөгөөд бүрэлдэхүүнийг нь 5 жилийн хугацаагаар Улсын Их Хурлаас томилж, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга нь ажлын шаардлагыг харгалзан бүтэн буюу хагас /хавсарсан/ орон тоогоор ажиллаж байхаар Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуульчилжээ. Мөн Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарахаар заасан билээ.

Иймд Сонгуулийн ерөнхий хороо бол парламентаас байгуулагдаж, нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засаглалан шийдвэр гаргадаг, сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөж, зохион байгуулах, сонгуулийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах; сонгуулийн тойргийн хорооны шийдвэрийг давж заалдсан гомдол, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргаан бүхий бусад өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу хянан шийдвэрлэх зэргээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн байгууллага мөн.

Сонгуулийн ерөнхий хорооноос гаргаж буй шийдвэр нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан "захиргааны акт" гэсэн тодорхойлолтод бүрэн нийцэж байгаа юм. Өөрөөр хэлбэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр нь 1/захиргааны байгууллагаас гаргасан захирамжилсан шийдвэр, 2/нийтийн эрх зүйн хүрээнд үүссэн тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан, 3/эрх зүйн үр дагавар шууд биш болгосон, 4/ гадагшаа чиглэсэн зэрэг шинжээрээ захиргааны актд хамаарна. Харин өргөдөл гаргагч нарын тайлбарласан шиг Үндсэн хуулийн шинжтэй акт биш юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8 дахь заалтын дагуу шүүгч захиргааны акт нь Үндсэн хууль зөрчсөн нь тогтоогдсон бөгөөд Үндсэн хуулийн цэцийн маргаан бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, Үндсэн хуулийн цэцэд шилжүүлэхээр хуульчилсан юм. Иймд өргөдөлд дурдсан "Үндсэн хуулийн бус эрх зүйн харилцааны хүрээнд захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж байх давуу боломжийг захиргааны хэргийн шүүхэд олгосон байна" гэсэн саналыг зөвшөөрөх боломжгүй юм.

Мөн "сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг гагцхүү Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэж байхаар зааж өгсөн нь тодорхой байна" гэж өргөдөлд дурдсаныг зөвшөөрөх боломжгүй. Учир нь: Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад "ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заасан билээ. Үүнээс үзэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэртэй холбогдсон маргаан Үндсэн хуулийн цэцэд хамаарахгүй бөгөөд энэ нь захиргааны хэргийн шүүхэд харьяалагдаж байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь төрийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа нийтийн эрх зүйн субьектын хувьд тус улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна. Эдгээр хууль тогтоомжийн нэгийг зөрчсөн шийдвэр гаргасан тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд биш захиргааны хэргийн шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.



Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооноос гаргасан захиргааны хууль бус актыг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна." гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "4.1.1. Монгол Улсын Засгийн газар" гэсэн заалт Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1. Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "4.1.6. Сонгуулийн ерөнхий хороо" гэсэн заалт Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-ын 2 дахь заалтыг зөрчсөн болох нь дараахь үндэслэлээр тогтоогдож байна.

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна.

Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна.

Захиргааны хэргийн шүүхэд төрийн гүйцэтгэх дээд байгууллагын шийдвэрийг хянах эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2.Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй

тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна.

3.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4.1.2 заалтад "Ерөнхий сайд" гэж оруулсан нь Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 1, Дөчин нэгдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн асуудлаар Монгол Улсын иргэн С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нар өргөдөл гаргаагүй харин нэмэлт тайлбартаа дурдсан бөгөөд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй учир дүгнэлт гаргах боломжгүй гэж үзэв.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн "Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаан" гэсэн 4 дүгээр зүйлийн "...дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ" гэсэн 1 дэх хэсгийн 4.1.1-д "Монгол Улсын Засгийн газар" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн" Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн заалтуудыг, мөн 4.1.6-д "Сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан нь Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-ын ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргах тухай заалтыг тус тус зөрсөн байна.

2.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногт багтаан энэхүү дүгнэлтийг хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай харууруулахыг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН
Ж.АМАРСАНАА
Ч.ДАШНЯМ
Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
"Төрийн Мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12,

Төрийн ордон

☎ 329612

Индекс 14003

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487

Хэвлэлийн хуудас 2.5